

Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

Хувилбар -9

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
 2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (Е.)
 3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (Е.)
- /1./ Пневмотораксын үед илрэх нийтлэг шинжийг нэрлэнэ үү.
- А. Ханиалгана
 - В. Аюулхайд өвдөнө
 - С. Цээж өвдөх, амьсгаадах
 - Д. Цустай цэрээр ханиах
 - Е. Тогшилтоор хэнгэргэн дуутай байх
- /2./ Уушгины дэлбэнгийн үрэвслийн үед дараахаас бусад хүндрэл илэрч болно.
- А. Пневмосклероз
 - В. Уушгины цус алдалт
 - С. Шүүдэст плеврит
 - Д. Уушгины буглаа
 - Е. Рестриктив хэлбэрийн амьсгалын дутагдал
- /3./ Сүрьеэгийн каверныг уушгины буглаанаас ялгах шинжийг тодорхойлно уу:
- А. Хөндий цацагдсан голомтуудын хамт
 - В. Гөлгөр ханатай, шингэний түвшинтэй хөндий
 - С. Цустай цэр гарна
 - Д. Хордлогын шинж
 - Е. Эритроцитын тунах хурд ихсэх
- /4./ БЦЖ вакциныг
- А. Арьсан дор тарина
 - В. Арьсанд тарина
 - С. Булчинд тарина
 - Д. Уулгана
 - Е. Хамарт дусаана
- /5./ Уушгины том хэмжээний нээгдсэн буглааны үед дараахаас бусад шинжүүд гарна:
- А. Цэрний хэмжээ ихсэх
 - В. Хордлогын шинжүүд багасах
 - С. Голомтотнд тогшилтын дуу богиносч, амьсгал суларсан
 - Д. Голомтонд тогшилтоор хэнгэргэн дуутай, гуурсан хоолойн эсвэл амфорын амьсгалтай
 - Е. Биеийн халуун буурах
- /6./ Уушгины архаг бөглөрөлт өвчин юунд хүргэх вэ?
1. Биеийн байдал муудах
 2. Эрт нас барах
 3. Амьдралын чанар буурах
 4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэмэгдэх
 5. Ачаалал даах чадвар буурах

- /7./ 30-45 насны хүнд уушгины эмфизем үүсэх шалтгаан юу байж болох вэ?
1. Тамхи татах
 2. Агаарын бохирдол
 3. @1-антитрипсины дутагдал
 4. Үлээвэр хөгжим үлээх
 5. Гуурсан хоолой тэлэгдэх
- /8./ Транссудатын шалтгааныг сонгоно уу.
1. СКВ
 2. Нефроз хам шинж
 3. Лимфом
 4. Гипотиреоз
 5. Сүрьеэ
- /9./ Торх хэлбэрийн цээж үүсэх шалтгаан:
1. Уушгины сүрьеэ
 2. Уушгины эмфизем
 3. Цээжний булчингийн миастени
 4. Уушгины архаг бөглөрөлт өвчин
 5. Өвчүүний гаж хөгжил
- /10./ Уушгины үрэвслийн нэвчдэс “удаан” шимэгдэж байх шалтгааныг нэрлэнэ үү
1. Уушгины хавдар
 2. Гуурсан хоолойн гадны биет
 3. Уушгины сүрьеэ
 4. Антибиотик эмчилгээ оновчтой бус байх
 5. Уушгины секвестр
- /11./ Бөөрний архаг дутагдлын эхэн үед дараах шинж тэмдгүүд илэрнэ.
- A. Артерийн даралт ихсэх
 - B. Их уух, их шээх
 - C. Цусан дахь калийн хэмжээ ихсэх
 - D. Цусан дахь кальцийн хэмжээ ихсэх
 - E. Цусан дахь фосфорын хэмжээ буурах
- /12./ Шээсний доод замын үрэвслийн үед шээс ялгаралтын өөрчлөлтийн аль нь илрэх вэ?
- A. Анури
 - B. Гематури
 - C. Странгури
 - D. Никтури
 - E. Олигури
- /13./ Артерийн гипертензийн хожуу үед шээсэнд гарах өөрчлөлт
- A. Лейкоцитури
 - B. Гематури+глюкозури
 - C. Протейнури+гематури
 - D. Оксалатури
 - E. Гипостенури
- /14./ Фольгардын сорилоор дараах зүйлийг тодорхойлно
- A. 1 мин-ын диурез, бөөрний фильтраци үзэх
 - B. Шингэний ачаалал өгч, бөөрний шингэрүүлэх үйл ажиллагааг үзэх
 - C. 1 мин-ын эзэлхүүнд дүрст элемент тодорхойлох
 - D. 24 цагийн шээсэнд дүрст элемент тодорхойлох
 - E. 3,3 цагийн зайтай шээс цуглуулж бөөрний үйл ажиллагааг үзнэ
- /15./ Бөөрний түүдгэнцэрт дараах процесс явагдана
- A. Реабсорц
 - B. Филтрац
 - C. Секрец
 - D. Филтрац болон секрец
 - E. Секрец болон филтрац
- /16./ Нефроз хам шинжийн үед дараах шинж тэмдгүүд илэрнэ
1. Псевдоанеми

2. Цээжний хөндийд шингэн үүснэ
 3. Хэвлийн хөндийд шингэн үүснэ
 4. Гидроперикард үүснэ
 5. Тархи хавагнах
- /17./ Бөөрний судасны шалтгаант гипертензийг ямар аргаар оношлох вэ?
1. Радиоизотопийн шинжилгээ
 2. Рентген шинжилгээ
 3. Хэт авиан доплерографи
 4. Хэт авиан шинжилгээ
 5. Бөөрний эдийн шинжилгээ
- /18./ Бөөрний хамгаалах зорилгоор дээрх эмийн бэлдмэлүүдээс хэрэглэнэ
1. АХФ ингибитор
 2. А, В, Е бүлгийн витаминууд
 3. АР блокатор
 4. Димефосфон
 5. Канефрон
- /19./ Бөөрний түүдгэнцэрийн гаралтай уураг алдалтын шалтгаан болж болох өвчин эмгэгийг нэрэлнэ уу
1. Түүдгэнцэрийн анхдагч эмгэгүүд
 2. Халдварууд
 3. Чихрийн шижин
 4. Холбогч эдийн эмгэгүүд
 5. Эмийн бодисууд
- /20./ Архаг тубулоинтерстициал нефритын үед бөөрний ямар үйл ажиллагаа эхэлж алдагдах вэ?
1. Шүүлтүүрийн үйл ажиллагаа
 2. Шээс ялгаруулах үйл ажиллагаа
 3. Биологийн идэвхитэй бодис ялгаруулах үйл ажиллагаа
 4. Шээс өтгөрүүлэх үйл ажиллагаа
 5. Цус бүлэгнэлтийг зохицуулах үйл ажиллагаа
- /21./ Изотопт ренографи нь бөөрний эмгэг судлалын практикт өргөн хэрэглэгддэг хоёр бөөрний үйл ажиллагааг харьцуулан судалдаг рентген шинжилгээний арга мөн.
- /22./ Гломерулонефрит нь халдварын шалтгаантай бөөрний эдийн үрэвсэлт өвчин учир эмчилгээнд стероид үйлдэлтэй үрэвслийн эсрэг эмийг дундчаар 14 хоног хэрэглэнэ
- /23./ Улаан хоолойн үндсэн үүрэг юу бэ?
- A. Хоол хүнсийг залгих
 - B. Хоолыг жижиглэх
 - C. Хоолыг залгиураас ходоод руу дамжуулах
 - D. Гүрвэлзэх хөдөлгөөн хийх
 - E. Хэхрэх, гулгих
- /24./ Цөсний ялгаралтыг идэвхижүүлдэг гормон аль нь вэ?
- A. Глюкагон
 - B. Адреналин
 - C. Холецистокенин
 - D. Кортизол
 - E. Инсулин
- /25./ Омепразолтой харьцуулахад давсны хүчлийг 97% бууруулдаг, бикарбонатын ялгаралтыг нэмэгдүүлж салст бүрхэвч хамгаалдаг, H.pylori-ийн эсрэг үйлчилгээ нь 4 дахин эмийн бэлдмэлийг нэрэнэ үү?
- A. Лансопразол
 - B. Пансопразол
 - C. Роксатидин
 - D. Фамотидин

Е. Е. Низатидин

/26./ Архаг энтеритын үед ямар бүлгийн бэлдмэлийг хэрэглэхгүй вэ.

- А. Фермент
- В. Аргаах бэлдмэл
- С. Амин дэм
- Д. Антибиотик
- Е. Биологийн бэлдмэлүүд

/27./ Нойр булчирхайн архаг үрэвсэл сэдэрсэн үед үүсэх эмгэг бүтцийг хэлнэ үү?

- А. Нейтрофиль, эозинофиль эсийн нэвчдэс
- В. Эсийн хатингаршил
- С. Холбогч эдэн сорвижил
- Д. Хавагнаж, өөхөн үхжил, уйланхай үүснэ
- Е. Холбогч эдэн ургалт

/28./ Өтгөн гарах үед.....

- 1. Дууны хөвч бүрэн агшина
- 2. Бүдүүн гэдэсний хэсэгчилсэн хөдөлгөөн саатна
- 3. Хэвлийн дотоод даралт ихсэнэ
- 4. Хэвлийн ханын булчин агшина
- 5. Аарцгийн булчигууд суларна

/29./ Улаан хоолойн сөөргөө өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг сонгоно уу?

- 1. Стресс
- 2. Таргалалт
- 3. Архи тамхи хэрэглэх
- 4. Биеийн хэвтээ байрлал
- 5. Өрцний ивэрхий

/30./ Гэдэсний дүүрэнгэ (метеоризм) бууруулахад хэрэглэх эмийг сонгоно уу?

- 1. Карболен
- 2. Атропин арьсан дор тарих
- 3. идэвхжүүлсэн нүүрс уух
- 4. Сөдийн уусмал уух
- 5. Циметидин тарих

/31./ Архаг дуоденитыг эмнэлзүйн илрэлээр нь хэрхэн ангилах вэ?/

- 1. Шархлаа төст
- 2. Гастрит төст
- 3. Холецистит төст
- 4. Панкреатит төст
- 5. Холимог, далд

/32./ Улаан хоолойн сөөргөө өвчний эмийн эмчилгээний зарчмыг сонгоно уу?

- 1. Ходоодны шүүрэл бууруулах
- 2. Хөдөлгөөн зохицуулах
- 3. Салст хамгаалах
- 4. Агчил тавиулах
- 5. Өвдөлт намдаах

/33./ Мухар гэдсэнд хоолны агуулагдахуун дахин хооллох хүртэл хэсэг саатах бөгөөд ходоод гэдэсний шинэ рефлекс нарийн гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэж химус цааш орно.

/34./ Бүдүүн гэдэсний архаг үрэвслийн үед суулгалт нь усархаг, хөөс ихтэй гарна. Суулгалтын эмгэг жам нь бүдүүн гэдэсний ханаас ялгарах энтерокиназа ферментийн дутагдалтай холбоотой.

/35./ ЧШ-гийн удамшлын асуумжтай тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авах нь илүү үр дүнтэй вэ?

- А. Хурц халдвараас сэргийлэх
- В. Таргалалтаас сэргийлэх

- C. ЧШ-тэй хүнтэй гэрлэхгүй байх
 - D. Сэтгэл санааны хямралд орохгүй байх
 - E. Бүгд зөв
- /36./ Тархмал хордлогот бахуугийн йод 131 эмчилгээний заалтыг хэлнэ үү
- A. хөнгөн хэлбэрийн бахуу
 - B. 1-р зэргээр томорсон бахуу
 - C. хүүхэд нас
 - D. жирэмсэн ба хөхүүл үе
 - E. мэс заслаар авсны дараа дахисан бахуу
- /37./ Гипокортицизмын эмчилгээнд алийг сонгох вэ?
- A. Кортикостероидын синтезийг нэмэгдүүлэх
 - B. Серотонины эсрэг бэлдмэл
 - C. Кортикостероидын синтезийг бууруулах
 - D. Дофаминыг дэмжигч бэлдмэл
 - E. Адрогеныг багасгах
- /38./ Тархмал хордлогот бахуугийн үед лабораторийн шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?
- A. TR-Ab ихэснэ
 - B. Нийт ба чөлөөт T3, T4 буурна
 - C. Холестерин, липопротеид, нийт уураг, альбумин ихсэх
 - D. ТТГ ихэснэ
 - E. Бамбай булчирхайд цацраг идэвхт йод 131 шингээлтийг үзэхэд 20-40% байх
- /39./ Тархмал хордлогот бахуугийн үед дархлааны ямар үзүүлэлтүүд алдагдах вэ?
- A. Тхел/Тсуп ↓
 - B. Тсуп ↑
 - C. Тхел ↓
 - D. В лимфоцит ↑
 - E. Т лимфоцит ↑
- /40./ Йод дутлын эмгэгийн үед дааврын талаас ямар өөрчлөлт гарах вэ?
- 1. Тиролиберин буурна
 - 2. T3, T4 буурна
 - 3. Тиреоглобулин ихэснэ
 - 4. Тиреотропин ихэснэ
 - 5. T3 буурч, T4 ихэснэ
- /41./ Инсулины бүтцийг нэрлэнэ үү
- 1. Нүүрс ус
 - 2. Уураг
 - 3. Фермент
 - 4. Даавар
 - 5. Өөх тос
- /42./ Чихрийн Шижин хэвшинж 2-ийн үед элгэнд гликогены задрал ихсэж глюкоз ихээр үүсдэг. Учир нь ЧШ-гийн үед глюкозоны ялгарал ихэсдэг.
- /43./ Ямар ч өвдөлтгүй, эмнэл зүйн илрэлгүй хүмүүст титэм судасны эмгэгийг илрүүлэх зорилгоор эмийн сорилтой зүрхний хэт авиан оношлогоо хийдэг. Ямар эмийн бэлдмэлийг энэхүү сорилд түлхүү ашигладаг вэ?
- A. Пропроналлол
 - B. Добутамин
 - C. Атропин
 - D. Допамин
 - E. Нитроглицерин
- /44./ Нитроглицерины гол гаж нөлөөг заана уу
- A. Бөөлжис цутгах
 - B. Суулгах
 - C. Ханиалгах
 - D. Толгой өвдөх
 - E. Хоолонд дүргүй болох

/45./ Зүрхний шигдээс сорвижих үед ЗЦБ-д гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү?

- A. Эмгэг Q шүд илрэх
- B. ST-T сегмент голч тэнхлэгээс доош буух
- C. ST-T сегмент голч тэнхлэгээс дээш өргөгдөх
- D. T шүд урвуу болох
- E. R шүд намсах

/46./ Титэм судсан дотуурх эмчилгээ хийх явцад зүрхний шигдээс үүссэн. Энэ нь ямар хэлбэрийн шигдээс вэ?

- A. I хэлбэр
- B. II хэлбэр
- C. III хэлбэр
- D. IV хэлбэр
- E. V хэлбэр

/47./ Зүрхний зүүн ховдлын ханын зузааралтыг анхдагч артерийн гипертензийн үед тодорхойлох нь ямар ач холбогдолтой вэ?

- A. Шалтгааныг олох
- B. Өвчний үе шатыг тодорхойлох
- C. Эмчилгээг сонгох
- D. Хүндрэлийг тодорхойлох
- E. Ялган оношлох

/48./ Дараах эмгэгүүдээс аль нь зүрхний гэнэтийн үхлийн шалтгаан болох вэ?

- 1. Титэм судасны цочмог хам шинж
- 2. Вирусны миокардит
- 3. Гиперкалиеми
- 4. Кардиомиопати
- 5. Вольф-Паркинсон-Вайтын хам шинж

/49./ Ямар гажгийн үед уушгины гипертензи үүсэх магадалал илүү вэ?

- 1. Митрал хавхлагын нарийсал
- 2. Ховдол хоорондын таславчийн цоорхой
- 3. Гурван хавтаст хавхлагын харьцангуй дутагдал
- 4. Аортын хавхлагын нарийсал
- 5. Митрал хавхлагын дутагдал

/50./ Артерийн даралт ихсэх өвчний 3-р үеийг 2-р үеээс ялгах шинжүүдийг сонгоно уу?

- 1. Нүдний угийн өөрчлөлт (Г. Салюсын шинж)
- 2. Зүрхний дутагдал илрэх
- 3. ЗЦБ-т зүүн ховдлын томрол илрэх
- 4. ЗИӨ хавсран илрэх
- 5. Аортын цэгт 2-р авиа тод сонсогдох

/51./ Зүрх зогсох үед зүрхний цахилгаан бичлэгт ховдлын фибрилляци илэрвэл ямар эмчилгээ хийх вэ?

- 1. 200 J, 200-300J, 360J –р 3 удаа дифибрилляци хийнэ
- 2. Гурван удаа хийгээд үр дүнгүй бол давтан хийнэ
- 3. Эхний эмчилгээ үр дүнгүй тохиолдолд мөгөөрсөн хоолойд гуурс тавина
- 4. Содны уусмал тарина
- 5. Адреналин судсаар тарина

/52./ Баруун ховдлын шигдээсийн үед алийг нь хэрэглэх хориотой вэ

- 1. Допамин
- 2. Шээс хөөх бэлдмэл
- 3. Дигоксин
- 4. Нитроглицерин тариагаар
- 5. Декстран 70

/53./ Зүрхний шигдээсийн дараа зүүн ховдлын цүлхэн үүсдэг. Цүлхэн нь зүрхний архаг дутагдал үүсэх эрсдлийг ихэсгэнэ

/54./ Удамшлын микросфероцитоз өвчний үед гарах өвөрмөц шинжүүдээс аль шинж нь орохгүйг дурдана уу?

- A. Нахиу хамар
- B. Хүнхэр тагнай
- C. Хуруугүй төрөх
- D. Шүдний хэлбэр өөрчлөгдсөн
- E. Хөл шилбээрээ майга

/55./ Шөнийн шээсэнд гэнэт гемоглобин гарах эмгэгийн үед цус задрал хаана явагдах вэ?

- A. Эдийн дотор
- B. Судсан дотор
- C. Холимог
- D. Элгэнд
- E. Чөмгөнд

/56./ Түгмэл миеломын аль хэлбэрийн үед сийвэнгийн нийт уураг ихсэхгүй вэ?

- A. Түгмэл миелома A
- B. Түгмэл миелома G
- C. Түгмэл миелома D
- D. Түгмэл миелома M
- E. Түгмэл миелома E

/57./ Хемоптиз гэдэг нь....

- A. 5 см болон түүнээс дээш диаметр хэмжээтэй, арьсны түвшингээс овойгоогүй
- B. Хэмжээний хувьд үзэгний үзүүр төдий олон тооны цусархаг тууралт
- C. Дотор эрхтний гаралтай цус алдалт
- D. 5 см хүртэлх диаметр хэмжээтэй, ихэвчлэн судас тойрон гардаг тууралт
- E. Цустай ханиах, цустай цэр гарах зэрэг амьсгалын эрхтэн системээс илрэх өөрчлөлт

/58./ FAB ангилалын дагуу M3 гэж ямар лейкозыг тэмдэглэдэг вэ?

- A. Хурц миеломонобластын лейкоз
- B. Хурц промиелоцитын лейкоз
- C. Хурц эритробластын лейкоз
- D. Боловсорсон, хурц миелобластын лейкоз
- E. Боловсроогүй, хурц миелобластын лейкоз

/59./ Цочмог лимфобластын лейкокийн тавилангийн хувьд муу үзүүлэлтүүдийг нэрлэнэ үү?

- 1. Өвчтөний нас ≥ 50 нас
- 2. Лейкоцитын тоо өндөр $>30 \times 10^9/\text{л}$ байх
- 3. Иммунофенотипийн хувьд: Про-B болон про-T эсийн ЦЛЛ
- 4. Цитогенетикийн хувьд: Ph хромсом илрэх
- 5. Бүрэн засралд орох хугацаа удаан байх ($>4-5$ долоо хоног)

/60./ Г-6-ФДГ ферментийн дутагдлаас үүсдэг ЦЗЦБ-ын үед захын цусны түрхцэнд илрэх өөрчлөлт:

- 1. Улаан эс бөмбөлөг хэлбэртэй болох
- 2. Гейнцийн биет агуулсан улаан эс
- 3. Бай хэлбэрт улаан эсүүд
- 4. Хазагдсан улаан эсүүд
- 5. Нулимсны дусал хэлбэрийн улаан эсүүд

/61./ Эмэгтэйчүүдэд жирэмслэхээс хамгаалах дааврын эмийг хэдийд хэрэглэхэд илүү тохиромжтой вэ?

- A. 35 хүртэлх насны
- B. Төрсний дараа шууд
- C. 35-45 хүртэлх насны
- D. Үр хөндсөний дараа
- E. 45 наснаас дээш

/62./ Умайн салстын хэт зузаарлыг найвдартай оношилох аргыг нэрлэнэ үү

- A. Эхо
- B. Умайг дурандах
- C. Умайн хөндийгөөс эсийн шинжилгээ авах
- D. Гистеросальфингографи

- Е. Умайн салстыг хусаж гистологи шинжилгээ хийх
- /63./ Леопольдийн 4-р аргаар юуг тодорхойлох вэ?
- А. Умайн ёроолын өндрийн түвшин
 - В. Ургийн байрлал, хэлбийлт
 - С. Түрүүлсэн хэсэг
 - Д. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
 - Е. Ургийн жин
- /64./ Жирэмсэн үед бэлэг эрхтэнд дараах физиологийн өөрчлөлтүүд илэрнэ:
- 1. Үтрээний салст хөхөлбөр болно;
 - 2. Бэлгийн уруулын тосны булчирхай шүүрэл ялгарал ихсэнэ
 - 3. ГБЭ хөөнгөтнө
 - 4. Хэлүү томорно
 - 5. Хярзан төмбийнө
- /65./ Ямар эрсдэлт хүчин зүйл илэрсэн жирэмсэн эмэгтэйг өрхийн эмч дараах шатны эмнэлэг рүү шилжүүлэх вэ?
- 1. Анхны төрөлт
 - 2. 18-аас доош настай
 - 3. Өмнө нь 5-аас олон удаа төрж байсан
 - 4. Өмнөх хүүхэд амьгүй төрсөн
 - 5. Өмнө нь кесар хагалгаагаар төрсөн
- /66./ ЭМС –ын 39 тоот тушаалын жирэмсэн эмэгтэйд эмнэлгийн тусламж үзүүлэх журамын хүрээнд өрх сумын эмчийн хийх ажилыг нэрлэнэ үү
- 1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл гаргана
 - 2. Төмөр, фолийн хүчлийн бэлдмэлээр болон бусад урьдчилан сэргийлэх эмчилгээг хийж, жирэмсэн үеийн дасгалд бүрэн хамруулна.
 - 3. Эсэн мэнд амаржихуйн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх
 - 4. Эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үзлэг хийж, эрүүл мэндийн бүлгээр ангилан. эмчлэн эрүүлжүүлнэ
 - 5. Жирэмснийг эрт илрүүлэн жирэмснийг тээлгэх эсэх болон оношилгоо эмчилгээний асуудлыг нь шийдвэрлэнэ
- /67./ Цээжний гялтан хальсны цочмог идээт үрэвслийн үед ямар шинж гардаггүй вэ?
- А. Цээжээр өвдөх
 - В. Хавирга завсарын зай өргөсөх
 - С. Тогшиход хэнгэрэн чимээ сонсогдох
 - Д. Дамуазын шугам тодорхойлогдох
- /68./ Голчийндоод хэсгийн идээг нээсний дараа хэсэг газрын эмчилгээг хэрхэн хийх вэ?
- А. Шарханд чихээс тавих
 - В. Гоожуурга тавьж сорогчоор соруулах
 - С. Шархан дундуур гоожуурга тавих
 - Д. Шарханд дундуур гуурсаа явуулан үзүүрийг нь гадагшлуулах
 - Е. Шархыг гуурсаар угааж, соруулах
- /69./ 12 хуруу гэдэс гэмтсэн үед түүнд үзлэг хийхдээ яах ёстой вэ?
- А. 12 хуруу гэдсэнд үзлэг хийхдээ хөндлөн хүрээ гэдсийг доош нь болгоно
 - В. Бага сэмжийг зүснэ
 - С. Ходоод-хүрээ гэдэсний холбоосыг зүснэ
 - Д. Кохерын аргаар 12 хуруу гэдсийг ялгана
 - Е. Чацархайн судаснаас баруун тийш 12 хуруу гэдсийг ил гартал хөндлөн хүрээ гэдэсний чацархайг зүснэ
- /70./ Осолдогч хүзүүний нугалам, нурууны гэмтэлтэй байх үед ойр зуур зөөж холдуулахад ямар аргыг сонгох вэ?
- А. Нэг аврагч сугадаж
 - В. Хоёр аврагч сугадаж
 - С. Нэг аврагч үүрч
 - Д. Хоёр аврагч чагталсан гар дээр өргөх
 - Е. Хувцасных мөрнөөс зөөлөн чирэх

/71./ Гэмтсэн өвчтөнийг шаардлаггүй үед хөдөлгөж, зөөхөд ямар сөрөг нөлөө гарч болох вэ?

1. Хугарсан яс арьсийг цоолох
2. Хугарсан яс зөөлөн эд, судас гэмтээх
3. Цус алдалтыг нэмэгдүүлэх
4. Шарханд халдвар орох
5. Өвдөлт нэмэгдүүлэх

/72./ Түвэнх хоолойн ургац буюу кандиломтой өвчтөн бачуурч байвал ямар арга хэмжээ авах вэ?

- A. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
- B. Түвэнх хоолойн ургацыг мэс засал хийх авах
- C. Антибиотик
- D. Хими, туяа эмчилгээ
- E. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ

/73./ Морфин уугаад унтаад, сэрэх чадваргүй байгаа өвчтөнд өрхийн эмч ямар ялган оношлогоо хийж, ямар арга хэмжээ авах вэ?

1. Олон хоног өвдөлтөөсөө болж нойргүй байсан өвчтөн өвдөлтгүй болсноор нойроо нөхөн унтаж байж болно, гэхдээ түүний амьсгалын тоо хэвийн байх ёстой.

2. Морфины унтуулах гаж үйлчилгээ илэрч байж болно, гэхдээ өвчтөний амьсгалын тоо цөөрөөгүй бол сандрах зүйлгүй, амьсгалыг хянах хэрэгтэй.

3. Морфины унтуулах гаж үйлчилгээ, амьсгал дарангуйлах гаж үйлчилгээтэй хамт илэрч байвал, сэрээхийг оролдох, хордлого тайлах дусал хийх, антидотыг хэрэглэх шаардлагатай.

4. Хэт хожуу морфин эхэлсэн тул үр дүнгүй өвчтөн үхэж байж болзошгүй.

5. Морфин уусан хүн бүр эхлээд унтамхай болдог тул санаа зовох хэрэггүй.

/74./ Хуурамч бульбар сааны үед гэмтэх бүтцүүд:

- A. IX,X,XII хосын бөөмс
- B. IX,X,XII хосын кортико-нуклеар зам
- C. IX,X хосын мэдрүүл
- D. Nucleus dorsal
- E. Nucleus ambiguus

/75./ Полиомиелитын эмнэлзүйн хэлбэр

1. Гүүрийн хувилбар
2. Нугасны хувилбар
3. Уртавттар тархины хувилбар
4. Хүзүүний хувилбар
5. Бүсэлхийн хувилбар

/76./ Сүрьеэгийн анхдагч бүрдэл гэж юу вэ?

A. Уушгинд сүрьеэгийн гэмтэл үүсдэг анхдагч сүрьеэгийн хэлбэр юм

B. Уушгины эд үрэвсэж гэмтэхийн хамт угийн тунгалгийн булчирхай гэмтдэг хэлбэр.

C. Уушгинд анхдагч голомтот өөрчлөлттэй, тунгалгийн судасны болон угийн булчирхайн үрэвсэлтэй анхдагч сүрьеэгийн нэг хэлбэр юм.

D. Анхдагч сүрьеэгийн байршлаа олсон хэлбэр юм.

E. Дээрхи бүгд

/77./ Хөндийт сүрьеэтэй өвчтөний цэрний түрхэцийн шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх вэ ?

A. Сүрьеэгийн савханцар илэрнэ

B. Сүрьеэгийн савханцар огт илрэхгүй

C. Уян ширхэг илэрнэ

D. Зөв хариулт бол А ба С юм

E. Дээрхи бүгд

/78./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн хүндэрлийг тоочно уу?

1. Анхдагч хөндий

2. Гуурсан хоолойн сүрьеэ

3. Сорвит хөндийт сүрьеэ

4. Ателектаз

5. Нурууны ясны сүрьеэ

/79./ Уушгины сүрьеэгийн сэжигтэй шинжүүдийг тоочно уу?

1. 14 хоногоос дээш хугацаагаар ханиах
2. Цэртэй, цустай ханиах
3. Цээжээр өвдөх
4. Халуурч, хөлрөх
5. Турах

/80./ Цочмог E гепатит гэдгийг батлах оношын маркерыг сонгоно уу?

- A. HBsAg
- B. Анти HBc-IgM
- C. Анти HD-IgM
- D. Анти HEV-IgM
- E. Анти HAV-IgM

/81./ Бруцеллийн халдвар авсан болохыг илрүүлэх харшил сорил тавихад ашигладаг бодисыг тэмдэглэ.

- A. Дизеитерии
- B. Бруцеллин
- C. Антраксин
- D. Туберкулин
- E. Тулерин

/82./ Гепатитын С болон Д вирусийн халдвар дамжиж болох замуудыг сонго.

1. Агаар дусал
2. Бэлгийн зам
3. Хоол боловсруулах
4. Арьс салстын шархаар
5. Шавьж ба дамжуулагч

/83./ Ёлом өвчний эмнэл зүйн ангилалд хамаатай асуудлыг доорхи хариултаас тохируулан сонго.

1. Эритематоз хэлбэр
2. Эритематоз – буллез
3. Буллез – цусархаг
4. Шархлаат
5. Фибринт өнгөрт

/84./ Хоёр нүдний хугалах хүч адилгүй байхыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Гиперметропи
- B. Миопи
- C. Анизометропи
- D. Астигматизм
- E. Эмметропи

/85./ Кератомалаяц нь

1. 65-аас дээш насанд голчлон тохиолдоно
2. Эврэвч бүр мөсөн хайлж ууссан байна
3. Бактерийн хурц халдварын дараа ихэвчлэн тохиолдоно
4. Өвчний тавилан муу, нүд ширгэх хүртэл хүндрэл тохиолдоно
5. Антибиотик эмчилгээнд үр дүнтэй

/86./ Аккомодациитай холбоогүй хялар үүсгэх шалтгаан

1. Шулуун булчингийн парез
2. Хугарлын гажиг
3. Тархи нугасны саа
4. Астигматизм
5. Анизометропи

/87./ Нармайн гүйлсний томролтын ангиллыг хэлнэ үү

- A. Жижиг, дунд зэрэг, том
- B. Ээнэгшилтэй, ээнэгшилгүй,
- C. Хөөнгөшилт ба хатингаршилт
- D. 1, 2, 3-р зэрэг
- E. Хэвийн ба эмгэг томролт

/88./ Холестеатомын хүндрэл юу вэ?

1. Менингит
2. Идээт болон шүүдэст лабиринтит
3. Нүүрний мэдрэлийн саа
4. Тахир ангалын бөлөн
5. Тархины буглаа

/89./ Бага насны хүүхдийн төвөнх бүтэц, үйлийн хувьд онцлогтой (1). Бөгж мөгөөрсний эргэн тойронд судасжилтаар баялаг, хөвсгөр холбогч эд ихтэй (2). Ийм тул бага насны хүүхэд бачуурлаар амархан хүндэрдэг.

/90./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөгрүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьегийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар өвчин байх магадлал илүү өндөр байна вэ?

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/91./ Түрүү булчирхай нь томорсон настанд ямар шинжүүд илрэх вэ?

1. Томорсон түрүү булчирхай давсгийг дарж буй тул давсаг дүүрсэн мэт санагдан, ойр ойрхон шээс хүрнэ.

2. Шөнө босж шээдэг болно.
3. Шээсний урсгал сул болно.
4. Дүлж шээдэг болно.

5. Шээсний дараа давсаг сулраагүй мэт санагдана

/92./ 78 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 10% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч Кальц, Даминдэм бичиж өгсөн ба кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэхийг зөвлөсөн. Тэр эмэгтэй залуугаасаа эхлээд чихэртэй байхуу, кофе уудаг байсан ба сүү, цагаан идээ хэрэглэж заншаагүй байв. Сүү, тараг хэрэглэж эхэлсэн өдрөөсөө тэр суулгаж, суулгалтанд Котримоксазол, Фталазол, Бифидум бактерин, Линекс зэргийг уусан боловч суулгалт намдахгүй 10 хонов. Тэр ямар шалтгаантай суулгасан бэ?

- A. Кальцийн бэлдмэл уусан тул
- B. Сүү нь муудсан тул суулгасан
- C. Лактазагийн дутагдалтай тул суулгасан
- D. Дисбактериоз болсон тул
- E. Д аминдэм суулгуулдаг тул

/93./ 72 настай өвгөнийг өрхийн эмч анх үзсэн. Тэр ярих, явах, биеийн ачааллын үед амьсгааддаг, биеийн хөнгөн ажил хийх үед амьсгааддаг, шөнө ханиалгадаг, зүрх дэлсдэг гэсэн зовиуртай эмчид үзүүлсэн ба үзлэгээр түүний зүрхний зохилт минутанд 120, хөлний шагай орчим хавантай, элэг томорсон шинж илэрсэн байв. Тэр 52 наснаасаа артерийн даралт өндөртэй байсан ба даралтанд энап 10 ууж, хэвийн болдог байсан. Эмээ хааяа нэг уудаг. Үзлэгээр даралт нь 160/90 байв. Өөр эмгэг шинж илрээгүй. Түүнд их эргэлтийн зогсонгишлын ямар шинжүүд байна вэ?

1. Ярих, явах, биеийн ачааллын үед амьсгааддаг
2. Хөлний шагай орчим хавантай
3. Шөнө ханиалгадаг
4. Элэг томорсон
5. Зүрхний цохилт олширсон, минутанд 120

/94./ Нурууны радиографи шинжилгээ хийх зорилгод нийцэхгүйг заана уу.

- A. Нуруу нугаламын бүтэц, байршил, хэлбэрийг тогтоох
- B. Гажиг илрүүлэх
- C. Гэмтэл илрүүлэх
- D. Нугалам хоорондын дарагдсан мэдрэл илрүүлэх
- E. Нугалам хоорондын мөгөөрсөн хэсгийн өөрчлөлт илрүүлэх

/95./ Хэрх төст үений үрэвслийн (Rheumatoid arthritis) эхэн үед рентгэнд илрэх өөрчлөлтийг нэрлэнэ үү.

- 1. Ясны шалбархай
- 2. Үе орчмын остеопени
- 3. Мөгөөрсний гадаргуу барзайх
- 4. Зөөлөн эдийн хаван
- 5. Үений бүтцийн эвдрэл

/96./ Эрхтэн тогтолцооны чонон хөрвөсийн цусны талаас гарах өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү:

- 1. Лейкоцитоз
- 2. Лейкопения
- 3. Тромбоцитоз
- 4. Тромбопения
- 5. Лимфоцитоз

/97./ Тулайн артритын шалтгааныг нэрлэнэ үү.

- 1. Халдвар
- 2. Архидалт
- 3. Тамхидалт
- 4. Шээс хөөх эм
- 5. Мэс засал

/98./ Хайрст үлдийн үений үрэвслийн үед рентгэнд илрэх өөрчлөлт

- 1. Үений зай нарийсах
- 2. Нэвчдэст шалбархай
- 3. Ясны нягтрал ихсэх
- 4. Үений гадаргуу хэлбэрээ алдах
- 5. Мөгөөрсөн доорх уйланхай

/99./ Ревматоид артритын оношлогооны шалгуурт аль нь нийцэх вэ:

- 1. Цагираг улайлт
- 2. Өглөөний хөшингө 1 цагаас илүү байх
- 3. Үеэр хэрж өвдөх
- 4. Үений үрэвсэл хоёр талдаа ижил байх
- 5. RF эерэг байх

/100./ Цус задлагч β стрептококк нь Ревматоид артрит өвчин үүсэх шалтгаан болдог бөгөөд энэ өвчний үед антибиотик эмчилгээг аль болох эрт хийх шаардлагатай байдаг.

Сорилын зөв хариулт

1-С, 2-В, 3-А, 4-В, 5-С, 6-Е, 7-В, 8-С, 9-С, 10-Е, 11-В, 12-С, 13-С, 14-В, 15-В, 16-Е, 17-В, 18-В, 19-Е, 20-Д, 21-В, 22-Д, 23-С, 24-С, 25-В, 26-В, 27-Д, 28-Е, 29-Е, 30-В, 31-Е, 32-А, 33-А, 34-Е, 35-В, 36-Е, 37-А, 38-А, 39-Д, 40-С, 41-С, 42-А, 43-В, 44-Д, 45-А, 46-Д, 47-В, 48-Е, 49-А, 50-С, 51-А, 52-С, 53-А, 54-А, 55-В, 56-С, 57-Е, 58-В, 59-Е, 60-С, 61-Д, 62-Е, 63-Д, 64-А, 65-Е, 66-Е, 67-С, 68-Е, 69-Д, 70-Е, 71-Е, 72-В, 73-А, 74-В, 75-А, 76-С, 77-Д, 78-С, 79-Е, 80-Д, 81-В, 82-С, 83-А, 84-С, 85-С, 86-В, 87-Д, 88-Е, 89-А, 90-В, 91-Е, 92-С, 93-С, 94-Д, 95-С, 96-С, 97-Е, 98-В, 99-С, 100-Е,